



Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

ХЭА-2024/40-ШТА-ГА

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ТАРИЛГАД ЗАРЦУУЛСАН
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
САНХҮҮГИЙН НӨӨЦ
ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

Хэрлэн сум
2024 он



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйл мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ:

МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮГИЙН НӨӨЦ ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

Тайланг хүргүүлсэн этгээд: Үндэсний аудитын газар, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аймгийн Мал эмнэлгийн газар

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:



Хэнтий аймаг, Хэрлэн сум, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар,

e-mail: khentii@audit.gov.mn, Утас:7056-2112

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

Аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Үүнд:

- ✓ *Аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, хянах тогтолцоо бүрдсэн эсэх,*
- ✓ *Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцин нь хугацаандаа нийлүүлэгдэн хийгдэж, үр дүнг хянаж байгаа эсэх,*

Аудитад Аймгийн ИТХ, аймгийн Засаг даргын Тамгын газар түүний хэлтсүүд, аймгийн Мал эмнэлгийн газар, сумдын мал эмнэлгийн тасаг, аудитад хамрагдагч тал болох мал эмнэлгийн хувийн аж ахуйн нэгжүүд болон холбогдох бусад байгууллагуудыг хамрууллаа.

Ерөнхий мэдээлэл:

Мал аж ахуйн салбарын бодлогын 2020-2025 оны хөгжлийн хандлага, стратегийн зорилтод уламжлалыг хадгалсан бэлчээрийн аж ахуй, дэвшилтэт технологи бүхий эрчимжсэн аж ахуйг хослуулан хөгжүүлж, нөөцийг тогтвортой, зохистой ашиглан ногоон эдийн засгийн чиг баримжааг дэмжихэд суурилна гэж тодорхойлсон.

Энэ хүрээнд аймгийн Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрт мал эмнэлгийн чанар хүртээмжийг дээшлүүлэх, оношилгоо шинжилгээний чадавхыг нэмэгдүүлэн малын гаралтай гоц халдварт өвчний гаралтыг бууруулах зорилт дэвшүүлсэн байна.

Мал аж ахуйн салбар нь Хэнтий аймгийн эдийн засгийн бүтцэд томоохон хэсгийг эзлэх бөгөөд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2021 онд 52.6 хувь, 2022 онд 51.9 хувийг тус тус эзэлж байна.

Малыг халдварт болон гоц халдварт өвчнөөс сэргийлэх ажлын хүрээнд малын гоц халдварт өвчний тарилгын зардлыг улсын төсөвт, халдварт өвчний тарилгын зардлыг орон нутгийн төсөвт тусган баталж хэрэгжүүлсэн байна.

Халдварт өвчнөөс сэргийлэх тарилгыг вакцины тээвэрлэлт, хадгалалтыг Мал эмнэлгийн ерөнхий газар, аймгийн МЭГ, сумын мал эмнэлгийн тасаг хариуцан ажиллаж, тарилгыг мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн аж ахуйн нэгжүүд хариуцан гүйцэтгэдэг байна.

Дүрслэл 1. Тарилгад хамруулсан малын тоо /давхардсан тоогоор/



Хэнтий аймагт малын гоц халдварт болон халдварт өвчний голомт 2021 онд 44, 2022 онд 44, 2023 онд 47 бүртгэгдэж, урьдчилан сэргийлэх тарилгад 2021 онд 98.0 хувь, 2022 онд 98.4 хувь, 2023 онд 97.8 хувийг дархлаажуулсан байна.

Малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх ажилд улсын төсвөөс 2021 онд 1,765.3 сая төгрөг, 2022 онд 1,625.8 сая төгрөг, 2023 онд 3,715.6 сая төгрөг, халдварт өвчнөөс сэргийлэх ажилд орон нутгийн төсвөөс 2021 онд 359.5 сая төгрөг, 2022 онд 334.6 сая төгрөг, 2023 онд 324.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна.


АУДИТЫН ГОЛ ҮР ДҮН:

БҮЛЭГ А. МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ТАЛУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

А.1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, хамрагдвал зохих мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчний дархлаажуулалтад бүрэн хамруулаагүй байна.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн Бүсчилсэн хөгжлийн зорилт, Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийтдээ 2 зорилт, 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хэмжигдэхүйц, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан байх заалтыг хангахгүй байна.

Дүрслэл 2. Халдварт, гоц халдварт өвчний гаралт /оноор/




Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолоор баталсан Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын болон дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг 68 төрлийн гоц халдварт, халдварт өвчнөөс Хэнтий аймагт 2021-2023 онд шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах зэрэг 4 төрлийн гоц халдварт өвчин, боом, галзуу, бруцеллёз, листериоз зэрэг 4 төрлийн малаас хүнд халдварладаг зооноз өвчин, цусан халдвар, дуут хавдар, дотрын халдварт хордлого, гахайн цусан халдвар зэрэг халдварт 4 өвчин бүртгэгдсэн байна.

Энэ хугацаанд малын халдварт өвчний гаралт буурч, гоц халдварт өвчний гаралт өссөн үзүүлэлттэй байгаа нь өвчний гаралт буурсан байх зорилт бүрэн хангагдахгүй байгааг харуулж байна.

Аймгийн Мал эмнэлгийн газар нь 2021-2023 онд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдвал зохих малын тоог гарган аймгийн Засаг дарга болон Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлдэг ч Мал эмнэлгийн ерөнхий газар нь малын тоог хасаж баталж байгаа нь малыг эрүүлжүүлэх, эрүүл бүс болгох тухай бодлоготой нийцэхгүй байна.

Дүрслэл 3. Дархлаажуулалтад хамруулахаар баталсан малын тоо



А.2 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын санхүүжилт, хүний нөөц дутагдалтай байна.

Хүний нөөцийн талаар

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.8 -д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолоор “Сумын мал эмнэлэг, үржлийн нэгжийг сумын хөдөө аж ахуйн тасаг болгон өөрчилж, мал эмнэлгийн тасгийг шинээр байгуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлог, ажлын ачааллыг харгалзан орон тооны дээд хязгаарыг хөдөө аж ахуйн тасагт 3, мал эмнэлгийн тасагт 2 байхаар тус тус тогтоосон байна.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д¹ заасан бүтцийн дагуу Хэнтий аймагт мал эмнэлгийн үйлчилгээг аймгийн Мал эмнэлгийн газар, 18 сумын мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн 71 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. МЭГ болон сумдын мал эмнэлгийн тасгийн хүний нөөцийн судалгаа

Хүний нөөц	2021 он		2022		2023	
	Батлагдсан орон тоо	Гүйцэтгэл	Батлагдсан орон тоо	Гүйцэтгэл	Батлагдсан орон тоо	Гүйцэтгэл
Мал, амьтны эрүүл мэндийн алба	5	5	5	4	6	5
Лаборатори	5	5	5	4	5	4
Захиргаа, санхүүгийн алба	7	7	7	7	7	7
Мал эмнэлгийн газрын орон тоо	17	17	17	15	18	16
Сумдын мал эмнэлгийн тасгийн орон тоо /18 сум/	36	24	36	25	36	23
Нийт	53	41	53	40	54	39

Мал эмнэлгийн салбарын төрийн байгууллагуудад 2021 онд 12, 2022 онд 13, 2023 онд 15 орон тоо дутуу ажилласан байна. Үүнээс сумын Мал эмнэлгийн тасаг 2021-2023 онд батлагдсан орон тооны 63.9-69.4 хувиар хүний нөөцөөр хангагдсан байна.

Сумдын мал эмнэлгийн тасагт тархвар зүйчийн орон тооны ажиллах хүч 2021, 2022 онд 38.8 хувь, 2023 онд 55.5 хувийн дутагдалтай байгаа нь мал, амьтны тархвар зүйн судалгаа хийх, малын гаралтай өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх бодлогыг сум орон нутагт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болсон байна.

Мөн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн нэг малын эмчийн хариуцах малын тоог Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын 7.1.3-д² зааснаас 2.1-2.3 дахин их буюу дунджаар 83.7-аас 91.8 мянган мал ногдож байгаа нь стандартаас хэтэрсэн ажлын ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна.

Санхүүгийн нөөцийн талаар

Мал эмнэлгийн газраас малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зардлыг төлөвлөн улс, орон нутгийн төсөвт тусгуулахаар хүргүүлсэн саналаас улсын төсөвт 2021 онд 10.5, 2022 онд 23.0, 2023 онд 26.1 хувийг, орон нутгийн төсөвт 2021 онд 66.8, 2022 онд 80.4, 2023 онд 96.3 хувийг баталж хуваарилсан байна.

Улсын төсвийн санхүүжилтээр 2021 онд 1,379.9 сая, 2022 онд 1,180.6 сая, 2023 онд 1,690.1 сая төгрөгийг вакцин, тарилгын үйлчилгээний зардалд 2021 онд 668.4 сая төгрөг, 2022 онд 1,213.7 сая төгрөг, 2023 онд 1,390.3 сая төгрөгийг тус тус олгосон бөгөөд энэхүү санхүүжилтээр нийт малын 20.9 хувийг хамруулжээ.

1 “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэнэ”

2 “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх үед нэг малын эмчийн хариуцах малын тоо хонин толгойд шилжүүлснээр дөчин мянга (40.000)-аас ихгүй байна”

Орон нутгийн төсөвт малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын зардалд 2021 онд 452.8 сая, 2022 онд 538.5 сая, 2023 онд 539.7 сая төгрөгийг баталсан бөгөөд энэхүү санхүүжилтээр нийт малын 8.4 хувийг хамруулсан байна.

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн бүсчилсэн хөгжилд тусгасан малын өвчингүй эрүүл, халдваргүй бүс нутаг болгох зорилтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд улсын төсвөөс 7 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 23,182.6 мянган малыг хамруулахад 17,239.8 сая, орон нутгийн төсвөөс санхүүжих 4 төрлийн халдварт өвчний урьдчилан сэргийлэх тарилгад давхардсан тоогоор нийт 7,073.7 мянган малыг хамруулахад 7,106.1 сая төгрөгийн санхүүгийн нөөц тус тус шаардлагатай байна.

А.3. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр нөлөөтэй байдлыг үнэлээгүй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Мал эмнэлгийн газарт хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн боловч Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын зааснаар бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг үнэлж, цаашид арга хэмжээг үр, дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах талаар дүгнэлт, зөвлөмжийг өгөөгүй байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.1-т зааснаар бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сайжруулах, нэмэлт өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээг авах талаар зөвлөмжийг хүргүүлж ажиллах нь зүйтэй байна.

Аудитын хүрээнд төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа үйлчилгээний нэгж болон малчин иргэдэд тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох зорилгоор санал асуулгыг авч ажилласан.

Малчин өрхөөс мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаатай холбоотой асуулга авахад 40.5 хувь нь ямар нэгэн хүндрэлгүй үйлчилгээ үзүүлдэг, 33.5 хувь нь малыг тарилгүй үлдээдэг, мэргэжлийн бус хүнээр тарилга хийлгэдэг, вакцины үр дүн муу байдаг гэж үзсэн байна.

Дүрслэл 4. Малын дуудлага үйлчилгээтэй холбоотой хүндрэлийн талаар




Малын дуудлага үйлчилгээтэй холбоотой хүндрэлтэй байдлын талаар цаг хугацаандаа ирж үйлчилгээ үзүүлдэг гэж 31.5 хувь нь хариулсан бол хугацаа алдаж ирдэг, ирэхдээ эм бэлдмэл, багаж хэрэгсэлгүй ирдэг гэж 29.8 хувь, дуудлага өгөхөд ирдэггүй гэж 17.4, дуудлагын дагуу утсаар эмчилгээний заавар зөвлөгөөг өгдөг гэж 20.2 хувь нь хариулсан байна.

Аймгийн Мал эмнэлгийн газраас “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-ын /MNS 5368-2018/ хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавьж, хугацаатай үүрэг чиглэл өгөх, биелэлтийг хангуулж ажиллах, хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гэрээг цуцлах, улсын төсвөөс олгох ажил үйлчилгээний хөлсийг хувиар бууруулж хариуцлага тооцох замаар стандартыг хангуулж ажиллах шаардлагатай байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж үйл ажиллагаа явуулахад малчдын зүгээс ямар хүндрэлтэй асуудал үүсдэг талаар асуулгыг дүгнэхэд урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг гүйцэтгэхэд малчид малаа товлосон хугацаанд бэлэн байлгадаггүй, барьж бэхэлдэггүй, тарилгын хашаа, хоолой бэлэн бус, малчин өрхийн баталгааны тэмдэг, малын эрүүл мэндийн дэвтэр байхгүй зэрэг асуудал нийт 98.1 хувийг эзэлж байна.

Дүрслэл 5. Малчдын зүгээс гардаг хүндрэлтэй асуудлын талаар



Мөн гоц халдварт өвчний үед малын өвчлөлийн талаар дуудлагыг хугацаа алдаж өгдөг, өөрсдөө дур мэдэж эмчилгээ хийдэг, өвчилсөн малаа устгуулдаггүй зэрэг асуудлууд гаргадаг гэж 83.9 хувьд хариулсан бол өвчний талаар дуудлага өгдөггүй гэж 10.5 хувь нь хариулсан байна.

Мал эмнэлгийн газар, сумдын Мал эмнэлгийн тасгаас Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар малчдын хүлээх эрх, үүргийн талаар малчдад мэдээлэл өгөх, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар сануулах, мөн багийн Засаг даргын хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжилтийг хангуулах, хариуцлагын асуудлыг сумын Засаг даргатай байгуулах гэрээнд тусгайлан оруулах талаар санаачилга гарган ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ Б. МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХУГАЦАА, ВАКЦИНЫ ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТЫН ГОРИМЫГ МӨРДӨӨГҮЙ, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ ХИЙХГҮЙ БАЙНА.

Б.1. Малын халдварт өвчний эсрэг дархлаажуулалтын вакцины хадгалалт, тээвэрлэлт стандартын шаардлага хангахгүй байгаа нь вакцины чанарт нөлөөлөх эрсдэл үүсгэж байна.

Аймгийн Мал эмнэлгийн газраас “Биокомбинат” төрийн өмчит ХХК-тай 2021 онд 4 төрлийн өвчний эсрэг 154.3 сая төгрөгийн 7,342.1 литр вакцин, 2022 онд 4 төрлийн өвчний эсрэг 195.9 сая төгрөгийн 6,252.0 литр вакцин, 2023 онд 4 төрлийн өвчний эсрэг 215.4 сая төгрөгийн 5,255.8 литр малын гоц халдварт өвчний эсрэг вакциныг худалдан авах гэрээ байгуулсан байна. Гэрээний дагуу 2021 онд 4,427.6 литр, 4,377.0 мянган тун вакцин, 2022 онд 6,355.4 литр, 4,139.8 мянган тун вакцин, 2023 онд 5,465.8 литр 4,623.7 мянган тун вакциныг зааварт тусгагдсан зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслээр тээвэрлэж хүлээн авсан байна.

Аймгийн МЭГ, сумын ЗДТГ болон Мал эмнэлгийн үйлчилгээг эрхлэгч ААН-үүд вакцины зааварт тусгасан шаардлагыг хангасан хөргүүртэй тээврийн хэрэгслээр хангаагдаагүйгээс 2021 онд 4,398.2 литр, 3,444.9 мянган тун вакцин, 2022 онд 6,347.2 литр, 3,821.4 мянган тун вакцин, 2023 онд 5,463.6 литр 4,531.4 мянган тун вакцины тээвэрлэлтийг суудлын зориулалттай, ердийн тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн нь вакцины чанар алдагдаж, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт үр дүнгүй болох эрсдэлтэй байна.

Хадгалалтын хувьд аймгийн Мал эмнэлгийн газар нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакциныг зааварт тусгагдсан шаардлагыг хангасан өрөө, -21-ээс -86 градуст хадгалах хөргүүрийг, Батноров, Цэнхэрмандал сумдад вакцин хадгалах өрөө болон хөргөгчийг шийдвэрлэсэн нь вакцины чанарыг алдагдуулахгүй хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай 2021-2023 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцин хадгалах зориулалтын өрөө, хөргүүрийг 16 сум шийдвэрлээгүй нь вакцины чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Б.2 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад төлөвлөгөөний дагуу малыг бүрэн хамруулж байгаа ч тарилга товлосон хугацаандаа хийгдэхгүй байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь заалтыг үндэслэн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/47, 2022 оны А/28, 2023 оны А/19 тоот тушаалуудаар урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын товыг тус тус баталжээ. Төлөвлөгөөг үндэслэн аймгийн Мал эмнэлгийн газрын дарга 2021-2023 онуудад дархлаажуулалтын хуваарийг сум тус бүрээр баталсан байна.

Аймгийн хэмжээнд малын гоц халдварт өвчний гаралтыг сүүлийн 3 жилийн голомтын тоогоор авч үзвэл 2021 онд 17, 2022 онд 27, 2023 онд 36 голомт илэрч жил ирэх тутам гоц халдварт өвчний гаралт нэмэгдсэн байна. Нийт өвчлөлийн 42 хувийг хонины цэцэг, 27 хувийг шүлхий, 26 хувийг бог малын мялзан, үлдсэн 5 хувийг үхрийн арьс товруутах, хорт салст халуурал, гахайн африкийн мялзан эзэлж байна.

Дүрслэл 6. 2021-2023 онуудад гоц халдварт өвчний гаралт, дархлаажуулсан малын тоо



Төлөвлөгөөт дархлаажуулалтын гүйцэтгэлийг хянахад 2021 онд 2,286.6 мянган малыг дархлаажуулахаар төлөвлөж 98.5, 2022 онд 1,970.2 мянган малыг хамруулахаар төлөвлөж 99.6, 2023 онд 2,076.7 мянган мал хамруулахаар төлөвлөж 99.2 хувийг тус тус хамруулсан байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т зааснаар багийн Засаг дарга зарлан мэдээлэх үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар судалгааг цахимаар авахад судалгаанд хамрагдсан 78 иргэний 46 буюу 58 хувь нь хугацаанд нь авдаг, 9 буюу 11 хувь нь хугацаа хоцорч авдаг, 23 буюу 29 хувь нь мэдээлэл авдаггүй гэж хариулсан байна.

Б.3. Дархлаажуулалтын үр дүнгийн хяналтыг хийж байгаа боловч технологийн хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д дархлаажуулалтын технологийн хяналтыг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлэхээр заасны дагуу аймгийн Мал эмнэлгийн газар болон сумдын мал эмнэлгийн тасагт ажиллаж байгаа мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Мал эмнэлгийн ерөнхий газраас баталсан удирдамж чиглэлийн дагуу энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Малын халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд технологийн болон гүйцэтгэлийн хяналт хийх чиглэлээр МЭЕГ-аас баталсан удирдамжийн дагуу 2021-2023 онд хяналтыг хийж ажилласан байна. Хяналтын ажлын тайлангаас үзэхэд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай болон төлөвлөгөөт арга хэмжээг өрхийн мал эмнэлгийн дэвтрийн хөтлөлт, цахим системийн бүртгэлтэй харьцуулан тулгалт хийн зөвхөн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Малын эмийн салбар зөвлөлөөр хэлэлцэж Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан тухайн вакциныг хэрэглэх зааврын дагуу зохих нас, хүйстэй малын тарих хэсэгт, баталсан тунгаар тарилгыг хийж байгаа эсэх, холбогдох санамжийг хэрэгжүүлж байгаа зэрэг технологийн арга хэмжээнд хяналт хийхгүй байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д дархлаажуулалтын үр дүнгийн хяналтыг аймгийн мал эмнэлгийн лаборатори, шаардлагатай тохиолдолд улсын мал эмнэлгийн лаборатори хэрэгжүүлэхээр заасан байна.

Хүснэгт 2. Дархлаажуулалтын үр дүнгийн хяналт хийсэн мэдээлэл

д/д	Он	Өвчний нэр	Сумын тоо	Малчин өрхийн тоо	Малын тоо	Дархлаа тогтсон хувь	
						А хэвшил	О хэвшил
1	2021	Шүлхий	2	4	120		
2	2022	Шүлхий	18	54	324	80.2	96.9
3	2022	Бруцеллёз	3	45	1035	76.2	
4	2023	Шүлхий	18	54	324	83.9	84.3
5	2023	Бог малын мялзан	6	36	216	75	
НИЙТ			47	193	2019		

Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нар 2021-2023 онуудад Мал эмнэлгийн ерөнхий газрын захиалга, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн боловсруулсан арга зүй, удирдамжаар сонгосон сумдын 193 малчин өрхийн 2019 малаас тандалтад шаардлагатай сорьцыг цуглуулсан байна.

Малаас авсан сорьцын шинжилгээний дүнгээс үзэхэд 2022 онд бруцеллёз өвчний дархлаажуулалт 76.2, шүлхий өвчний дархлаажуулалт А хэвшилд 80.2, О хэвшилд 96.9 хувьд нь тогтсон байна. 2023 онд бог малын мялзан өвчний дархлаажуулалт 75, шүлхий өвчний дархлаажуулалт А хэвшилд 83.9, О хэвшилд 84.3 хувьд нь тогтсон гэсэн дүгнэлт гарчээ.

---o0o---

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

- ❖ Гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2022-2023 онд хамрагдвал зохих малыг бүрэн хамруулан хийснээр 2024 оны хагас жилийн байдлаар шүлхий 100 хувь, бог малын мялзан 91 хувь, хонины цэцэг өвчин 60 хувиар тус тус буурсан байна.
- ❖ Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, хамрагдвал зохих мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад бүрэн хамруулаагүй байна.
- ❖ Улс, орон нутгийн төсөвт малыг дархлаажуулах санхүүжилтийг 11,883.5 сая төгрөгөөр төлөвлөснийг 3,635.8 сая төгрөг болгон бууруулан баталснаар нийт малын 20.9 хувийг гоц халдварт, 8.4 хувийг халдварт өвчний дархлаажуулалтад хамруулж байгаа нь халдварт өвчингүй бүс болох зорилтыг хэрэгжүүлэх санхүүгийн нөөц хангалтгүй байгааг харуулж байна.
- ❖ Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр нөлөөтэй байдлыг үнэлээгүй, мал эмнэлгийн газраас малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын технологийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- ❖ Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад төлөвлөсөн малыг бүрэн хамруулсан ч зарим халдварт өвчний дархлаажуулалт товлосон хугацаандаа хийгдэхгүй байгаа нь хугацааны давхцал, малчдын идэвхигүй байдал, багийн Засаг даргын хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлэхгүй байгаатай холбоотой байна.
- ❖ Аймгийн төвөөс сум хүртэл 2021 онд 4,398.2 литр, 3,444.9 мянган тун вакцин, 2022 онд 6,347.2 литр, 3,821.4 мянган тун вакцин, 2023 онд 5,463.6 литр 4,531.4 мянган тун вакциныг зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн, 16 сумын Засаг даргын Тамгын газарт вакцин хадгалах өрөө, хөргүүр байхгүй байна.

---oOo---

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аймгийн Засаг дарга Д.Аюурбунь-д

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан малын өвчингүй эрүүл, халдваргүй бүс нутаг болох зорилттой уялдуулан аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгах арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх чиглэлээр дүгнэлт, зөвлөмжийг өгч ажиллах,

Сумдыг малын халдварт өвчний эсрэг вакцин хадгалах хөргүүр, зориулалтын тээврийн хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах,

Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Н.Анхбаяр-т

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг цаг хугацааны давхцалгүй төлөвлөх, мэдээллийг малчдад цаг алдалгүй хүргэх, ажлыг зохион байгуулах

Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын технологийн хяналтыг тогтмол хийж, баталгаажуулан үр дүнг тооцож холбогдох арга хэмжээг авч ажиллах

Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлэх САНАЛ:

Салбарын хэмжээнд нэн шаардлагатай мэргэжилтний нөөцийг бүрдүүлэх, мал, амьтныг эрүүлжүүлэх бодлогын хүрээнд урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдвал зохих мал, амьтныг төлөвлөгөөт дархлаажуулалтад бүрэн хамруулах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах

---oOo---